



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Цагаан-овоо сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/52/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Чойбалсан хот

2020 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: В.Цэнгэлмаа Утас: 70584204

Цахим хаяг: Tsengelmaav@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нармандах

Утас: 70584207 Цахим хаяг: Narmandakhd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч



<b>Аудитын гэрчилгээ</b> .....	3
Аудитын тайлан .....	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.13. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	10
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	10
Менежментийн захидал .....	11
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан .....	12
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан .....	12
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	14
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	15
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	16





**ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.02.19 № 107

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ЦАГААН ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
Э.ОТГОНХУЯГ ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цагаан-Овоо сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Цагаан-Овоо сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн туд зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Цагаан-Овоо сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110520028



**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



## 2.1. Оршил

Цагаан-овоо сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга, Э.Отгонхуяг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй, болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цагаан-овоо сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагаан-овоо сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 14-нөөс 2020 оны 02 дугаар сарын 16-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, ахлах аудитор Д.Нармандах хариуцаж хэрэгжүүлэв.

Цагаан-овоо сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 2/37 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Төрийн аудитын байгууллагаас



санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Цагаан-овоо сумын Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Харьяалах нутаг дэвсгэрийнх нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлаар төрийн эрх бүхий байгууллагаас батлах төсөл, хөтөлбөрт санал өгөх, тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулах”-д оршино.

Цагдаагийн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хурал, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах
- Хурал, Засаг даргын шийдвэрийг биелүүлэх үүрэг бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах,

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Цагаан-овоо сумын Засаг даргын тамгын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Цагаан-овоо сумын Засаг даргын тамгын газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Axplorer” программ хангамж ашигладаг байна.

Цагаан-овоо сумын Засаг даргын тамгын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

#### **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Цагаан-овоо сумын Засаг даргын тамгын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 21 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.



## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 446,055.8 мянган төгрөгөөс тооцон 8,921.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 11,333.3 мянган төгрөгөөр тооцсон нь зардлын гүйцэтгэл өмнөх оноос өссөнтэй холбоотой болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Цагаан-овоо сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 106,176.5 мянган төгрөгөөр буюу 5,5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	5,160.0	5,160.0
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	126,428.8	141,268.7	14,839.9
Үндсэн хөрөнгө	2,249,113.6	2,416,505.6	167,392.0
Хуримтлагдсан элэгдэл	-550,487.3	-631,702.7	-81,215.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,825,055.2</b>	<b>1,931,231.7</b>	<b>106,176.5</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,825,055.2	1,931,231.7	106,176.5
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,825,055.2</b>	<b>1,931,231.7</b>	<b>106,176.5</b>

Авлага дансны үлдэгдэл 5,160.0 мянган төгрөгөөр өссөн нь бэлтгэн нийлүүлэгч байгууллага багаж тоног төхөөрөмжийг нийлүүлээгүйгээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь малын үйлдвэр угсааг сайжруулах зорилгоор орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хар ямаа худалдан авсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд тусгай зориулалтын 29,013.5 мянган, бичиг хэргийн 30.6 мянган, аж ахуйн 761.0 мянган, түлш шатах тослох материалын 2,516.1 мянган, бусад хангамжийн 5,877.5 мянган, 103,070.0 мянган төгрөгийн мал амьтад байна



Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь орон нутгийн хөрөнгө оруулалт хийгдсэнтэй холбоотой байна.

Аймгийн хөрөнгө оруулалтаар 62,123.0 мянган төгрөгийн барилга байгууламж, 40,000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл 7,827.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 5,000.0 мянган төгрөгийн зам гүүр, 65,832.0 мянган төгрөгийн бусад хөрөнгө, сумын хөрөнгө оруулалтаар 9,921.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 3,755.0 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл, 932.2 мянган төгрөгийн санхүүгийн программ худалдан авснаар нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө акталсан 28,000.0 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Биет бус хөрөнгө өссөн нь 932,2 мянган төгрөгийн санхүүгийн программ хангамж худалдан авснаас шалтгаалсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өссөн/ буурсан өөрчлөлт ороогүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,931,231.7 мянган төгрөг болж 106,176.5 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгө оруулалтаас шалтгаалжээ.

## **2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан үндсэн үйл ажиллагаанд 408,536.3 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 408,536.3 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 408,536.3 мянган төгрөг буюу 100 хувьтай байна.

**Нэмэлт төсөв:** ОБЕГ-аас өмнөх онуудын гамшгийн ослын зардал 47,521.6 мянган төгрөг, ХААГ-аас үлийн цагаан оготно устгалд 21,140.0 мянган төгрөг, аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 43,216.8 мянган төгрөг, мал тооллогын 1,843.9 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийг хүлээн авсан байна.

Үүнээс 47,521.6 мянган төгрөгийг өмнөх онуудын гамшгийн томилолт болон шатахууны зардалд, үлийн цагаан оготно устгалын урамшуулал, шатахуун, багаж хэрэгсэл худалдан авахад 21,140.0 мянган төгрөгийг, 40,000.0 мянган төгрөгийг тээврийн хэрэгсэл худалдан авахад, жилийн эцсийн мал тооллогын шатахуун болон бусад зардалд 5,060.7 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

## **2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 21 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 21 эрсдэл тодорхойлж нийт 21 горим сорил хэрэгжүүллээ.



Аудитаар нийт 15,527.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 2,510.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 5,912.8 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 5,760.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 1,344.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 11,672.8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчилд төлбөрийн акт тогтоож, албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Нэмэлт санхүүжилтийн данснаас "Цэнгэлийн зүг" ХХК-д багаж тоног төхөөрөмж худалдан авахаар 5,160.0 мянган төгрөгийг шилжүүлэн орлогоор бүртгэсэн байна. Гэвч уг хөрөнгө бодитоор оршин байхгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6. дахь "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь "Төсвийн бүртгэлийг тохируулсан аккруэл сууриар бүртгэж, тайлагнана" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, тохиолдсон байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2. Засаг даргын нөөцийн сангаас 600.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн байна. Энэ СС-ын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2,2 дахь заалтын 2.2.1.2 дахь хэсэгт "энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад зориулалтаар тоног төхөөрөмж бэлтгэх, хөрөнгө оруулалтын зардал гаргах"-ыг хориглоно гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3. Санхүүгийн хяналт, шалгалтаар тогтоосон төлбөрийн актын 5,912.8 мянган төгрөгийг төсвөөс төлсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

Аудитаар илэрсэн 11,177.5 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## **2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Анхаарал татахуйц чухал асуудал байхгүй байна.

## **2.13. Шилэн дансны мэдээлэл**

Цагаан-овоо сумын Засаг даргын тамгын газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 141 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.



## **2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 800,0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосныг бүрэн барагдуулсан, 5,300.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.

Нийт 2 зөвлөмж өгснөөс хэрэгжилт 100 хувьтай байна.

## **2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Цагаан-овоо сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Цагаан-овоо сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Дотоод хяналтай холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Тайлант онд сумын Засаг дарга албан тушаалын суудлын автомашин хэрэглэн 1,344.2 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан байна.
- 1.2. Эрсдэл: Хөрөнгө арвилан хэмнэлт, үр ашиггүй зарцуулагдах.
- 1.3. Өгсөн зөвлөмж: ЗГ-ын тогтоолыг хэрэгжүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>126428832,80</b>	<b>146428745,80</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	0,00	5160000,00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	0,00	5160000,00
3351	Байгууллагаас авах авлага	0,00	5160000,00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	126428832,80	141268745,80
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	26489746,80	29013546,80
35110	Тусгай зориулалттай материал	26489746,80	29013546,80
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	6669086,00	9185199,00
35410	Бичиг хэргийн материал	30600,00	30600,00
35420	Аж ахуйн материал	761000,00	761000,00
35440	Түлц, шатах тослох материал	0,00	2516113,00
35470	Бусад хангамжийн материал	5877486,00	5877486,00
35600	Мал амьтад	93270000,00	103070000,00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1698626380,92</b>	<b>1784802932,20</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1698626380,92	1784802932,20
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1545036881,16	1630397777,22
39201	Барилга, байгууламж, орон сууц	558006715,05	620129715,05
39202	Хуримтлагдсан элэгдэл	-72609193,98	-102896920,86
39203	Авто-тээврийн хэрэгсэл	136302150,00	148302150,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-107344839,79	-82187148,07
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	134037043,25	151786843,25
39206	Хуримтлагдсан элэгдэл	-57230782,69	-79446413,50
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	34546946,77	38301946,77
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7605911,69	-12932268,91
39209	Зам, гүүрийн байгууламж	100646692,00	105646692,00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-79702469,14	-80981922,82
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	650000000,00	650000000,00
39214	Бусад үндсэн хөрөнгө	480831108,20	546663108,20
39215	Хуримтлагдсан элэгдэл	-224840576,82	-271988003,89
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	153589499,76	154405154,98
39301	Програм хангамж	4135000,00	5067200,00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1153500,24	-1270045,02
39303	Бусад биет бус хөрөнгө	150608000,00	150608000,00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1825055213,72</b>	<b>1931231678,00</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1825055213,72</b>	<b>1931231677,43</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1825055213,72	1931231677,43
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1589289263,57	1589289263,00
51101	Өмч: - төрийн	1589289263,57	1589289263,00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-100513098,63	5663365,65
51210	Өмнөх үеийн үр дүн	-100513098,63	-100513098,63
51220	Тайлант үеийн үр дүн	0,00	106176464,28
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	336279048,78	336279048,78
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1825055213,72</b>	<b>1931231677,43</b>



#### 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>427312687,78</b>	<b>672841568,00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>450000,00</b>	<b>184993557,00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	450000,00	184993557,00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	450000,00	184993557,00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	450000,00	34410657,00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0,00	9800000,00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	0,00	140782900,00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО</b>	<b>426862687,78</b>	<b>487848011,00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	27283078,33	79311711,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	27283078,33	79311711,00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	346511300,00	408536300,00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	346511300,00	408536300,00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>446055851,32</b>	<b>563231663,85</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>428256451,32</b>	<b>563231663,85</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	425390402,32	538694163,85
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	223772790,00	252892309,00
210101	Үндсэн цалин	218329590,00	240479309,00
210104	Урамшуулал	5443200,00	12413000,00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	26171907,32	29347415,13
210201	Тэтгэврийн даатгал	17319407,32	19616108,13
210202	Тэтгэмжийн даатгал	1770400,00	2493397,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2213100,00	1503394,00
210204	Ажилгүйдлийн даатгал	442700,00	1029072,00
210205	Эрүүл мэндийн даатгал	4426300,00	4705444,00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	6061108,00	11214452,00
210301	Гэрэл, цахилгаан	2609448,00	3337788,00
210302	Түлш, халаалт	3451660,00	7320664,00
210303	Цэвэр, бохир ус	0,00	556000,00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	23820515,00	33515667,00
210401	Бичиг хэрэг	2088433,00	4506600,00
210402	Тээвэр, шатахуун	14186985,00	16492327,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7377097,00	8803800,00
210404	Ном, хэвлэл	168000,00	1092000,00
210406	Бага үнэгэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0,00	2620940,00
2105	<b>Нормативт зардал</b>	830000,00	1020000,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	830000,00	1020000,00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2935500,00	8819250,00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0,00	2674000,00
210604	Урсгал засвар	2935500,00	6145250,00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	3835000,00	21760420,00
210702	Дотоод албан томилолт	3835000,00	21760420,00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3475622,00	1757396,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2592000,00	680000,00
210803	Даатгалын үйлчилгээ	247050,00	160740,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	193700,00	410064,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100000,00	88000,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	162280,00	238000,00
210807	Газрын төлбөр	180592,00	180592,00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	134487960,00	178367254,72
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21910000,00	69151806,00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	112577960,00	109215448,72
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	2866049,00	24537500,00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	2866049,00	24537500,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2692400,00	23537500,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	173649,00	1000000,00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-18743163,54</b>	<b>109609904,15</b>
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-18743163,54</b>	<b>109609904,15</b>



### 4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>373794378,33</b>	<b>522258668,00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>0,00</b>	<b>34410657,00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	0,00	34410657,00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0,00	34410657,00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0,00	34410657,00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>373794378,33</b>	<b>487848011,00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	27283078,33	79311711,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	27283078,33	79311711,00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	346511300,00	408536300,00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	346511300,00	408536300,00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>322098978,33</b>	<b>482258668,00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>322098978,33</b>	<b>482258668,00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>314232929,33</b>	<b>454287728,13</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	223772790,00	252892309,00
210101	Үндсэн цалин	218329590,00	240479309,00
210104	Урамшуулал	5443200,00	12413000,00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	26864908,33	29347415,13
210201	Тэтгэврийн даатгал	18012408,33	19616108,13
210202	Тэтгэмжийн даатгал	1770400,00	2493397,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2213100,00	1503394,00
210204	Ажилгүйдлийн даатгал	442700,00	1029072,00
210205	Эрүүл мэндийн даатгал	4426300,00	4705444,00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	6659008,00	12968215,00
210301	Гэрэл, цахилгаан	2609448,00	3337788,00
210302	Түлш, халаалт	4049560,00	9074427,00
210303	Цэвэр, бохир ус	0,00	556000,00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	29000101,00	34421017,00
210401	Бичиг хэрэг	1988433,00	4649600,00
210402	Тээвэр, шатахуун	19466571,00	17254677,00
210403	Шуудан, холбоо, интэрнэгийн төлбөр	7377097,00	8803800,00
210404	Ном, хэвлэл	168000,00	1092000,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0,00	2620940,00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	780000,00	3133800,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	780000,00	3133800,00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2935500,00	28033150,00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0,00	17894900,00
210602	Тавилга	0,00	4070000,00
210604	Урсгал засвар	2935500,00	6068250,00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3835000,00	21760420,00
210702	Дотоод албан томилолт	3835000,00	21760420,00



**Цагаан-овоо сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3475622,00	2579596,00
210803	Даатгалын үйлчилгээ	2592000,00	680000,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	247050,00	160740,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	193700,00	410064,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	100000,00	88000,00
210807	Газрын төлбөр	162280,00	1060200,00
210807	Газрын төлбөр	180592,00	180592,00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	16910000,00	69151806,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16910000,00	69151806,00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2866049,00</b>	<b>27970939,87</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	2692400,00	24537500,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2492400,00	23537500,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200000,00	1000000,00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох тагаас, санхүүжилт</b>	0,00	3433439,87
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		3433439,87
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>51695400,00</b>	<b>40000000,00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>0,00</b>	<b>40000000,00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>0,00</b>	<b>40000000,00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	0,00	40000000,00
223001	Бусад хөрөнгө	0,00	40000000,00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>0,00</b>	<b>-40000000,00</b>

**4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1 589 289 263,57	336 279 048,78	-100 513 098,63	1 825 055 213,72
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0,00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1 589 289 263,57	336 279 048,78	-100 513 098,63	1 825 055 213,72
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0,00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0,00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0,00
C07	Тайлант үеийн үр дүн				0,00
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1 589 289 263,57	336 279 048,78	-100 513 098,63	1 825 055 213,72
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1 589 289 263,57	336 279 048,78	-100 513 098,63	1 825 055 213,72
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0,00	0,00	0,00	0,00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1 589 289 263,57	336 279 048,78	-100 513 098,63	1 825 055 213,72
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0,00	0,00	0,00	0,00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0,00	0,00	0,00	0,00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0,00	0,00	0,00	0,00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0,00	0,00	0,00	0,00
D08	Тайлант үеийн үр дүн	0,00	0,00	106 176 464,28	106 176 464,28
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1 589 289 263,57	336 279 048,78	5 663 365,65	1 931 231 678,00



#### 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	408536300,00	405102860,13
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	408536300,00	405102860,13
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	383998800,00	380565360,13
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	242347100,00	240479309,00
210101	Үндсэн цалин	242347100,00	240479309,00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	30293400,00	29347415,13
210201	Тэтгэврийн даатгал	20599500,00	19616108,13
210202	Тэтгэмжийн даатгал	2423400,00	2493397,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1348800,00	1503394,00
210204	Ажилгүйдлийн даатгал	1074700,00	1029072,00
210205	Эрүүл мэндийн даатгал	4847000,00	4705444,00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	12983500,00	12968215,00
210301	Гэрэл, цахилгаан	4378300,00	3337788,00
210302	Түлш, халаалт	8065200,00	9074427,00
210303	Цэвэр, бохир ус	540000,00	556000,00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	29736300,00	29736280,00
210401	Бичиг хэрэг	4584300,00	4649600,00
210402	Тээвэр, шатахуун	12581600,00	12668940,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9170400,00	8803800,00
210404	Ном, хэвлэл	800000,00	993000,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2600000,00	2620940,00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	3133800,00	3133800,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3133800,00	3133800,00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	22877000,00	22873150,00
210601	Багаж, техник, хэрэгсэл	14877000,00	12734900,00
210602	Тавилга	2000000,00	4070000,00
210604	Урсгал засвар	6000000,00	6068250,00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	11498700,00	11483500,00
210702	Дотоод албан томилолт	11498700,00	11483500,00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2757000,00	2579596,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400000,00	680000,00
210803	Даатгалын үйлчилгээ	440700,00	160740,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	410100,00	410064,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88000,00	88000,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1137200,00	1060200,00
210807	Газрын төлбөр	281000,00	180592,00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	28372000,00	27964095,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	28372000,00	27964095,00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	24537500,00	24537500,00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	24537500,00	24537500,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23537500,00	23537500,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1000000,00	1000000,00

